

## **УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ТУХАЙ**

**/Шинэчилсэн найруулга/**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь хэрэглэгчийг төвлөрсөн инженерийн шугам сүлжээгээр дамжуулах болон инженерийн шугам сүлжээгээр дамжуулахаас бусад хэлбэрээр холбогдох дүрэм, журам, заавар, стандартад заагдсан хэм хэмжээнд нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай барилга, байгууламж, шугам сүлжээ, техник, тоног төхөөрөмжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино .

#### **2 дугаар зүйл.Ус хангамж, ариутгах татуургын тухай хууль тогтоомж**

2.1. Ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Цэвэр усыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахтай холбогдсон харилцааг Усны тухай хуулиар зохицуулна.

2.3. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### **3 дугаар зүйл.Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний зарчим**

3.1.Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээнд дараах зарчмыг баримтална:

3.1.1.ус хангамж, ариутгах татуургын тогтолцооны нэгдмэл байдлыг хангах;

3.1.2.хэрэглэгч болон хангагч байгууллагын эрх ашиг, ашиг сонирхлыг хамгаалах, хадгалах;

3.1.3.ус хангамж, ариутгах татуургын хүртээмжийг сайжруулах, үр ашигтай, хэмнэлттэй ашиглах;

3.1.4.хэрэглэгч болон хангагч байгууллагуудад тэгш хандах;

3.1.5.ус хангамж, ариутгах татуурга ашигласны төлбөрийн хэмжээг зардал, үр өгөөжийн харьцаанд тулгуурлан тогтоох;

3.1.6.ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн байгууллагуудын үйл ажиллагаа нээлтэй, ил тод байх.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“төвлөрсөн ус хангамж” гэж ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглан хэрэглэгчийг **холбогдох дүрэм, журам, заавар**, стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах үйл ажиллагааг;

4.1.2.“төвлөрсөн бус ус хангамж” гэж төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс бусад эх үүсвэрээс усыг зөөвөрлөн түгээж, хэрэглэгчийг холбогдох дүрэм, журам, заавар, стандартад заагдсан хэм хэмжээнд нийцсэн цэвэр усаар хангах үйл ажиллагааг;

4.1.3.“ариутгах татуурга” гэж хэрэглээнээс гарсан бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламж, **нүхэн жорлонгоос<sup>1</sup>** бусад ариун цэврийн байгууламжийг;

4.1.4.“ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж” гэж гүний болон гадаргын ус ашиглан ус олборлох, цэвэршүүлэх, цуглуулах шугам сүлжээ, усан сан, шахуургын станцыг;

4.1.5.“шугам сүлжээ” гэж унд, ахуйн хэрэглээний хүйтэн, халуун ус дамжуулах, түгээх, хэрэглээнээс гарсан бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах байгууламжийг;

4.1.6.“цэвэр ус дамжуулах шугам” гэж ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжаас ус дамжуулах төв болон түүнтэй адилтгах төхөөрөмжтэй удирдах зангилаа хүртэлх шугам сүлжээг;

4.1.7.“цэвэр ус түгээх шугам” гэж ус дамжуулах төв болон түүнтэй адилтгах төхөөрөмжөөс хэрэглэгчийн тоолуурын өмнөх хаалт болон түүнтэй адилтгах төхөөрөмж хүртэлх шугам сүлжээг;

4.1.8.“бохир усны гаргалгааны шугам” гэж хэрэглэгчийн сантехникийн хэрэгслээс барилгын гадна талын эхний худаг хүртэлх шугам сүлжээг;

---

<sup>1</sup> Гэр хорооллын нүхэн жорлон, муу усны нүхийг хамтад нь ойлгохуйц байдлаар томъёолох шаардлагатай гэж үзэж байна.

4.1.9. “бохир ус цуглуулах шугам” гэж барилгын гадна талын эхний худгаас бохир ус татан зайлуулах шугамд холбогдож байгаа худаг хүртэлх шугам сүлжээг;

4.1.10. “бохир ус татан зайлуулах шугам” гэж бохир ус цуглуулах шугамд холбогдож байгаа эхний худгаас бохир ус цэвэрлэх байгууламжийн хүлээн авах сан хүртэлх шугам сүлжээг;

4.1.11. “цэвэрлэх байгууламж” гэж бохир ус татан зайлуулах шугамаас бохир усыг хүлээн авч цэвэрлэх цогц байгууламжийг;

4.1.12. “урьдчилан цэвэрлэх байгууламж” гэж үйлдвэрийн хэрэглээнээс гарсан бохир усыг хүлээн авч холбогдох дүрэм, журам, заавар, стандартад заагдсан хэм хэмжээнд хүртэл цэвэрлэж бохир ус татан зайлуулах төв шугамд нийлүүлэх байгууламжийг;<sup>2</sup>

4.1.13 “төвлөрсөн бус ариун цэврийн байгууламж” гэж Эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.10-т заасныг;<sup>3</sup>

4.1.14. “хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс” гэж Усны тухай хуулийн 3.1.9, 3.1.10-т заасныг;

4.1.15. “хэрэглэгч” гэж цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээгээр **үйлчлүүлж** байгаа иргэн, **хуулийн этгээдийг**;<sup>4</sup>

4.1.16. “хангагч” гэж унд, ахуйн хэрэглээний цэвэр усыг олборлох, цэвэршүүлэх, халуун, хүйтэн ус дамжуулах, нөөцлөх, түгээх, зөөвөрлөн түгээх, хэрэглээнээс гарсан бохир усыг цуглуулах, татан зайлуулах, тээвэрлэх, цэвэрлэх үйлчилгээг бүхэлд нь, эсхүл аль нэгийг нь үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

4.1.17. “аж ахуйн харилцааны дүрэм” гэж хангагч, дамжуулагч, түгээгч, хэрэглэгчийн хоорондын гэрээний нөхцөл, шаардлага, үйлчилгээний түвшин, чанар, төлбөрийн нөхцөлийг тусгасан хэм хэмжээ

---

<sup>2</sup> Ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөтөлбөр /2006/ -т “урьдчилсан цэвэрлэх байгууламж” гэж бохир усыг төвийн шугамд хаяхаас өмнө анхан шатны цэвэрлэгээ хийх зориулалттай барилга, байгууламж, тоног төхөөрөмж” гэж тодорхойлсон байна. Энэ нь УЦБ-г зөвхөн үйлдвэрээр хязгаарлахгүй байгаа нь давуу талтай байна.

<sup>3</sup> Эрүүл ахуйн тухай хуулийн 3.1.10. “төвлөрсөн бус ариун цэврийн байгууламж” гэж ариутгах татуургын төвлөрсөн системд холбогдоогүй, бага хүчин чадлын цэвэрлэх байгууламж, бохирын цооног, жорлонг; Харин Ариун цэврийн байгууламжийг сайжруулах хөтөлбөр /2006/ -ийн 1.3.1-т “ариун цэврийн байгууламж” гэж нийтийн бохирын шугам, цооног, агааржуулагчтай болон энгийн нүхэн жорлон, бохир усны төрөл бүрийн цэвэрлэх байгууламжийг” ойлгохоор тусгасан байна. Аль зохистойг нь хэрэглэх.

<sup>4</sup> Хуулийн этгээдийн талаар “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай” болон Компанийн тухай хуулиудад тусгасан байдаг. Харин Иргэний хуулийн 7 дугаар зүйлд. **Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч**: 7.1. Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна. Тухайлбал СӨХ нь энэ төрлийн байгууллага бөгөөд УХАТ-ын хэрэглэгч байх боломжийг үгүйсгэх юм. Иймээс “аж ахуйн нэгж, байгууллага” гэж оруулах шаардлагатай эсэхийг шийдэх шаардлагатай гэж үзлээ.

болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн харилцааг зохицуулсан хэм хэмжээг;

4.1.18. “техникийн нөхцөл” гэж шинээр барих, хүчин чадалд өөрчлөлт оруулах, барилга байгууламжийг ус хангамжийн болон ариутгах татуургын шугам сүлжээнд холбоход тавигдах шаардлага, нөхцөлийг тусгасан техникийн баримт бичгийг;

4.1.19. “цэвэр усны үйлчилгээний төлбөр” гэж усыг олборлох, цэвэршүүлэх, хүйтэн, халуун усыг дамжуулах, түгээх, зөөвөрлөн түгээх үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг;

4.1.20. “бохир усны үйлчилгээний төлбөр” гэж хэрэглээнээс гарсан бохир усыг цуглуулах, татан зайлуулах, тээвэрлэх, цэвэрлэх үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг;

4.1.21. “тариф” гэж цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр, эсхүл эдгээрийн аль нэгийг багтаан Усны үйлчилгээг зохицуулах хорооноос баталж нийтэлсэн үнийг;

4.1.22. “индексжүүлэлт” гэж цэвэр, бохир усны үйлчилгээний үнэ тарифыг цэвэр ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх, зөөвөрлөн түгээх, хэрэглээнээс гарсан бохир усыг цуглуулах, татан зайлуулах, тээвэрлэх, цэвэрлэх зардлын үндсэн хүчин зүйлсийн бодит өөрчлөлтөөс хамааруулан тооцож зохицуулахыг;<sup>5</sup>

4.1.23. “блок тариф” гэж хэрэглээний шинж чанар, хэрэглэж буй усны хэмжээ, ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэх зардал зэргийг үндэслэн төлбөрийн хэмжээг тогтоох зорилгоор хэрэглэгчийг ангилахыг;<sup>6</sup>

4.1.24. “ундны ус” гэж хүн ам, хүнсний зориулалтаар хэрэглэх, эрүүл ахуйн шаардлага хангасан, стандартад нийцсэн, өвчлөхгүй цэвэр уснаас бусад цэвэр усыг;<sup>7</sup>

4.1.25. “үйлдвэрлэлийн ус” гэж үйлдвэр, үйлчилгээний технологийн шаардлагад нийцсэн, тэдний хэрэгцээг хангаж байгаа усыг;<sup>8</sup>

<sup>5</sup> /ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНЭ ТАРИФЫГ ИНДЕКСЖҮҮЛЭХ ЖУРАМ/

<sup>6</sup> “Хэрэглэгчийн ангилал” эсхүл “блок тариф” гэх байдлаар тодорхойлох боломжтой

<sup>7</sup> ХҮНСНИЙ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ 2012. 3.1.1. “хүнс” гэж хүний бие махбодийн хэвийн үйл ажиллагааг хангах, эрүүл мэндийг дэмжин хамгаалахад шаардагдах хүнсний түүхий эд, хагас болон бүрэн боловсруулсан бүтээгдэхүүн, ундны усыг; 3.1.6. “стратегийн хүнс” гэж монгол хүний физиологийн хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай малын мах, сүү, тарианы үр, улаан буудай, гурил, ундны усыг;

- Усны тухай хууль: 4 дүгээр зүйл. Усны нөөцийн нэгдсэн менежмент: 4.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны нөөц нь стратегийн үнэт баялаг мөн.
- MNS 4079:2016 Усны чанар. Нэр томъёо тодорхойлолт. 13-р мөр: Ундны ус Стандарт хэмжилзүйн газар. УБ 2016 он.

<sup>8</sup> MNS 4079:2016 Усны чанар. Нэр томъёо тодорхойлолт. 37-р мөр: Ундны ус Стандарт хэмжилзүйн газар. УБ 2016 он. Үйлдвэрлэлийн ус.

Техникийн ус гэж томъёолох эсэхийг шийдэх

4.1.26. “саарал ус” гэж ахуйн хэрэглээнээс гарсан суултуурын бохир уснаас бусад бохир усыг;

4.1.27. “цэвэрлэсэн ус” гэж цэвэрлэх байгууламжаар дамжуулан хаягдал усны стандартад нийцтэл цэвэрлэсэн усыг;<sup>9</sup> /хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх болон дахин ашиглах зориулалтын чанарын шаардлагад нийцэх хүртэл боловсруулсан ус;<sup>10.1</sup>/

4.1.28. “лаг” гэж янз бүрийн төрлийн уснаас байгалийн эсхүл зориудын аргаар салгасан хуримтлагдсан хатуу бодис, хаягдлыг;<sup>10</sup>

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

#### 5 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

5.1. Засгийн газар ус хангамж, ариутгах татуургын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1. хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн ундны болон ахуйн хэрэглээний цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж цэвэршүүлэх үүрэг хүлээж, ус хангамж, ариутгах татуургын талаарх төрийн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтэд хяналт тавих;

5.1.2. усны үйлчилгээг зохицуулах үүрэгтэй зохицуулах хорооны дүрмийг батлах;

5.1.3. усны болон ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

5.1.4. ус хангамж, ариутгах татуургын хөрөнгө оруулалтын хэмжээг тогтоох, хяналт тавих;

5.1.5. ус, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор нүхэн жорлонгийн тоог бууруулах арга хэмжээний төлөвлөгөө батлах, шаардагдах санхүүжилтийг жил бүр улсын төсөвт тусгах;<sup>11</sup>

5.1.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

<sup>9</sup> MNS 4079:2016 Усны чанар. Нэр томьёо тодорхойлолт. 45-р мөр: Ундны ус Стандарт хэмжилзүйн газар. УБ 2016 он.

<sup>10.1</sup> MNS 6734:2018 Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага. 4.1 дэх тодорхойлолт: Стандарт хэмжилзүйн газар. УБ 2018 он.

<sup>10</sup> MNS 4079:2016 Усны чанар. Нэр томьёо тодорхойлолт. 198-р мөр: Ундны ус Стандарт хэмжилзүйн газар. УБ 2016 он.

<sup>11</sup> Хог хаягдлын тухай хууль./2017/ 9 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх 9.3.11. нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах арга хэмжээг авах, шаардагдах зардлыг шийдвэрлэх;

## **6 дугаар зүйл.Ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

6.1.Ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын норм, дүрэм, нийтлэг мөрдөх журам, заавар батлах, стандартыг хянах;

6.1.2.Усны тухай хуулийн 9.1.3-т заасны дагуу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд батлагдсан гадаргын болон гүний усны экологи, эдийн засгийн үнэлгээг мөрдүүлэх;

6.1.3.ус хангамж, ариутгах татуургын төрийн өмчийн барилга байгууламжийн захиалагчийн эрх, үүргийг Барилгын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид зааснаар хэрэгжүүлэх;

6.1.4.ус хангамж, ариутгах татуургын талаарх төрийн бодлогыг усны хэрэглээний хандлага, усны нөөц, ашиглаж болох боломжит нөөц, усны менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах;

6.1.5.гамшиг болон аюул үүссэн тохиолдолд ус хангамжийн талаар мөрдөх журам батлах;

6.1.6.үйлдвэрийн газрын технологийн хэрэглээний усыг дахин ашиглахтай холбогдсон норм, дүрэм, журмыг баталж мөрдүүлэх;

6.1.7.аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын хэрэглээний халуун, хүйтэн ус, ариутгах татуургын норм, дүрэм, журмыг баталж мөрдүүлэх;

6.1.8.ус, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор нүхэн жорлонгийн тоог бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, шаардагдах санхүүжилтийн талаарх саналыг боловсруулж Засгийн газраар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

6.1.9.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## **7 дугаар зүйл.Хот, суурины ус Ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх**

7.1.Ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль тогтоомж болон дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх;

7.1.2.ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, хүчин чадалд өөрчлөлт оруулах, төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

7.1.3.ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, хүчин чадалд өөрчлөлт оруулах,

төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төрийн бодлого боловсруулахад шаардлагатай тооцоо, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулах;

7.1.4.ундны усны эх үүсвэр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, хүчин чадалд өөрчлөлт оруулах, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох байгууллагад мэдээллэх;

7.1.5.ус олборлох, дамжуулах, түгээх үйл ажиллагааны явцад усны алдагдлыг бууруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал боловсруулах;

7.1.6.өрөн-нутгийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

7.1.7.ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийн нэгдсэн сан байгуулах, түүний байнгын ажиллагааг эрхлэх, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;

7.1.8.ус хангамж, ариутгах татуургын салбарын хүний нөөцийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

7.1.9.унд, ахуйн хэрэглээний цэвэр усыг хэмнэх, хэрэглээнээс гарсан бохир усыг **цэвэрлэн** дахин ашиглах, ариун цэврийн байгууламжийн стандартыг мөрдүүлэх чиглэлээр олон нийтэд сургалт, сурталчилгаа зохион байгуулах;<sup>12</sup>

7.1.10. тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгохтой холбогдон гарсан маргааныг хянаж мэргэжлийн дүгнэлт гаргах;

7.1.11.ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын норм, дүрэм, нийтлэг мөрдөх журам, заавар, стандартын төсөл боловсруулах;

7.1.12.ус хангамж, ариутгах татуургын төрийн өмчийн барилга байгууламжийн захиалагчийн үүргийг Барилгын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид зааснаар хэрэгжүүлэх, худалдан;

7.1.13. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## **8 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх**

8.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

---

<sup>12</sup>Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолын хавсралт “АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР” –ийн 4.5.1. агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд бодитой мэдээлэл өгч, зөв дадал хэвшилд сургах, иргэний байгаль орчныг хамгаалах журамт үүргийг таниулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

8.1.1. нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ус хангамж, ариутгах татуургыг хөгжүүлэх бодлого боловсруулах, биелэлтэд хяналт тавих, энэ талаар Засаг даргын тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх, дүгнэлтийг Зохицуулах хороонд хүргүүлэх;

8.1.2. нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд унд, ахуйн хэрэглээний ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох, хамгаалалтын зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусгах;

8.1.3. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## **9 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх**

9.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

9.1.2. нутаг дэвсгэрийнхээ унд, ахуйн хэрэглээний усны нөөц, ус хангамж, ариутгах татуургын талаар бодлого, төсөл, хөтөлбөр боловсруулан холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулж, хэрэгжилтийг хангах;

9.1.3. ус хангамж, ариутгах татуургын орон нутгийн өмчийн барилга байгууламжийн захиалагчийн үүргийг Барилгын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх, хяналт тавих, үр дүнг иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнах;

9.1.4. ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын мэргэжилтэн, хүний нөөцийн асуудалд дэмжлэг үзүүлэх;

9.1.5. тухайн нутаг дэвсгэр дэх цэвэр, бохир усны шугам сүлжээний хамгаалалтын зурваст баригдсан барилга, байгууламж, айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, дээрх зөрчлийг гаргуулахгүй байх арга хэмжээ авах;

9.1.6. усыг хэмнэх, хэрэглээнээс гарсан бохир усыг **цэвэрлэн** дахин ашиглах, ариун цэврийн байгууламжийн стандартыг мөрдүүлэх чиглэлээр олон нийтэд сургалт, сурталчилгаа зохион байгуулах;<sup>13</sup>

9.1.7. Хог хаягдлын тухай хуульд заасан хориглох үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, байгууллагад газрын зөвшөөрөл олгохгүй байх;<sup>14</sup>

---

<sup>13</sup> Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолын хавсралт “АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР” –ийн 4.5.1. агаар, орчны бохирдлын эх үүсвэр, хор уршиг, сөрөг нөлөөллийн талаар олон нийтэд бодитой мэдээлэл өгч, зөв дадал хэвшилд сургах, иргэний байгаль орчныг хамгаалах журамт үүргийг таниулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

<sup>14</sup> Хог хаягдлын тухай хуульд заасан сайжруулсан зорлонтой тохиолдолд газрын зөвшөөрөл олгодог байх үүргийг нэмэх саналыг Хог хаягдлын тухай хуулийн 10.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараахь үйл ажиллагааг хориглоно: 10.3.1. хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях; 10.3.6. аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах; заалттай уялдуулан нэмсэн.



9.1.7.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **УСНЫ ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

#### **10 дугаар зүйл.Усны үйлчилгээг Зохицуулах хорооны бүтэц**

10.1.Усны үйлчилгээг Зохицуулах хороо /цаашид “Зохицуулах Хороо” гэх/ нь тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах, хяналт, шалгалт хийх, хариуцлагын арга хэмжээ авах, усны хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.

10.2.Зохицуулах хороо нь дарга, дараах орон тооны бус дөрвөн гишүүний бүрэлдэхүүнтэй байна:

10.2.1.хэрэглэгчийн төлөөлөл нэг хүн;

10.2.2.салбарын мэргэжлийн төрийн бус байгууллагаас хоёр хүн;

10.2.3.салбарын төрийн болон орон нутгийн мэргэжлийн байгууллагаас нэг хүн.

10.3.Зохицуулах хорооны дарга, гишүүнийг ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Ерөнхий сайд томилно.

10.4.Зохицуулах хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна. Зохицуулах хорооны гишүүдийн анхны томилгоог 2, 4, 6 жилээр хийж, цаашид 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд томилолтын хугацааг нэг удаа сунгаж болно.

10.5.Зохицуулах хорооны дарга, гишүүнээр ус хангамж, ариутгах татуургын инженер, хот төлөвлөлтийн эдийн засагч, барилгын эдийн засагч мэргэжлийн аль нэгийг эзэмшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэнийг томилно.

10.6.Зохицуулах хорооны дарга, гишүүн нь ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдтэй нэгдмэл сонирхолтой байж болохгүй.

10.7.Зохицуулах хороо ажлын албатай байх ба ажлын албаны даргыг Зохицуулах хорооноос томилж, чөлөөлнө.

10.8.Зохицуулах хорооны орон тооны зохицуулагч болон холбогдох мэргэжилтэн нь ус хангамж, ариутгах татуургын хяналтын улсын байцаагчийн эрхтэй байна.

10.9.Зохицуулах хороо энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын болон үнэ, тарифыг хянан баталгаажуулах үйлчилгээний төлбөр, сургалт, сурталчилгаа, мэдээллийн орлогоос санхүүжинэ.

10.10.Зохицуулах хорооны ажлын албаны үйл ажиллагааны дотоод журмыг Зохицуулах хорооны дарга батална.

10.11.Зохицуулах хороо нь жил бүр тухайн жилийн үйл ажиллагааны төсвөө баталж, ажлын тайлан, төсвийн гүйцэтгэлийг ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тайлагнана.

10.12.Зохицуулах хороо нь санхүүгийн тайлангаа жил бүр аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлнэ.

10.13.Дор дурдсан тохиолдолд Зохицуулах хорооны дарга, гишүүний бүрэн эрх энэ хуулийн 10.4-т заасан хугацаанаас өмнө дуусгавар болно:

10.13.1.нас барсан;

10.13.2.чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргасан;

10.13.3.өөрийнх нь зөвшөөрснөөр өөр ажилд томилсон буюу сонгогдсон;

10.13.4.нэг жилээс дээш хугацаагаар сургалтад хамрагдсан болон биеийн эрүүл мэндийн байдлын улмаас үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон;

10.13.5.гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

10.13.6.хуульд заасан тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн;

10.13.7.хуульд заасан бусад үндэслэлээр.

10.14.Зохицуулах хороо нь бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэх асуудлыг хорооны хурлаар хэлэлцэх бөгөөд Зохицуулах хорооны хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

10.15.Зохицуулах хорооны шийдвэрийг тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч дагаж мөрдөнө.

10.16.Зохицуулах хороо нь эрхэлсэн ажлын онцлогыг илэрхийлсэн бэлгэдэлтэй байх бөгөөд тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

10.17.Зохицуулах хороо нь ус хангамж, ариутгах татуургын чиглэлээр хийх сургалт, сурталчилгааг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

10.18.Зохицуулах хороо нь өөрийн ажилтныг Төрийн албаны тухай хуульд заасантай дүйцэхүйц хэмжээгээр ажиллах нөхцөл, баталгаагаар хангана.

## **11 дүгээр зүйл.Зохицуулах хорооны бүрэн эрх**

11.1. Зохицуулах хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.цэвэр, бохир усны үйлчилгээний тарифын бүтцийг тодорхойлох, тариф тогтоох аргачлал боловсруулах, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх журам батлах, тариф тооцох аргачлал, түүнийг хэрэгжүүлэх журам болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйлчилгээний тарифыг хянаж батлах, нийтлэх;

11.1.2.энэ хуулийн 15.1.11-д заасан үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн хэмжээг тогтоох;

11.1.3.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

11.1.4.тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах;

11.1.5.тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх;

11.1.6.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрчлөн зохион байгуулагдах, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийг шинэчлэх, эд хөрөнгөө барьцаалах нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанд нөлөөлөхөөр бол тухайн өөрчлөлтийг зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэх;

11.1.7.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, хүний нөөц, техник технологи, санхүү, эдийн засгийн үзүүлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулах, мэдээллийн үнэн байдлыг хянаж, шалгах;

11.1.8.аж ахуйн харилцааны дүрэм батлах;

11.1.9.техникийн нөхцөл олгох журам батлах;

11.1.10.зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох аргачлал батлах;

11.1.12.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх журам батлах;

11.1.13. ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний норм, стандарт, дүрэм боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

11.1.14.бусдад цэвэр ус түгээх, тэдгээрийн хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах нөхцөлд хангагч, дамжуулагчийн хооронд хийх төлбөр тооцооны журам батлах;

11.1.15.ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн элэгдэл байгуулах журам батлах;

11.1.16.ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг хамгийн бага өртгөөр хүргэх чадавхийг бүрдүүлсэн, зохих ашгийн түвшин бүхий үнэ, тарифын тогтолцоог бий болгох;

11.1.17.энэ хуулийн 17.1.9-д заасан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянаж, хөрөнгө оруулалтыг нөхөн төлөх асуудлыг тарифын зохицуулалтаар шийдвэрлэх;

11.1.18.хэрэглэгчид ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид улсын төсвөөс олгох асуудлыг Засгийн газарт оруулах;<sup>15</sup>

11.2. Зохицуулах хороо тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үзүүлэх үйлчилгээний тарифыг хянан батлахдаа дараах зарчмыг баримтална:

11.2.1.цэвэр ус олборлох, цэвэршүүлэх, дамжуулах, түгээх, зөөвөрлөн түгээх, бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх үйл ажиллагаанд техник, технологийн найдвартай ажиллагааны шаардлагад нийцүүлэн хамгийн бага өртгийн зарчмыг мөрдөх;

11.2.2.тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардал, оруулсан хөрөнгийн өгөөж болон шугам хоолойн алдагдлыг жишиг нормативын хэмжээг тооцсон байх;

11.2.3.тарифын бүтэц хэрэглэгчид ойлгомжтой, энгийн байх;

11.2.4. тариф тогтоохдоо Өрсөлдөөний тухай хуулийн 5 дугаар зүйл, 6.1-д заасны дагуу үйл ажиллагааны бодит өртөг, зардалд тулгуурлах;

11.2.5.усны үйлчилгээний менежментийг нэвтрүүлэх, усны хэрэглээг зохицуулах боломжтой байх;

11.3.Тухайн суурин газарт хүн амыг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах үйлчилгээний тарифыг ижил түвшинд хүргэх бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

11.4. Зохицуулах хорооны дүрэмд заасан бусад эрх, үүрэг

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### **ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

#### **12 дугаар зүйл.Техникийн нөхцөл**

---

<sup>15</sup> Найруулгыг засах

12.1.Техникийн нөхцөлд дараах шаардлагыг тусгасан байна:

12.1.1.тухайн барилга байгууламжийг холбох цэгийн шугам сүлжээний голчийн хэмжээ, хоолойн суултын гүн, усны даралтын хэмжээ;

12.1.2.цэвэр, бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээ, тэдгээрийг шугам сүлжээнд нийлүүлэх нөхцөл;

12.1.3.цэвэр ус хэмнэлттэй зарцуулах, бусад хэрэглэгчийг холбох боломж;

12.1.4.шинээр баригдах барилга байгууламжийн зураг төсөлд саарал усыг цуглуулах, хуримтлуулах, цэвэрлэх, дахин ашиглах боломж.

12.2.Захиалагч, хөрөнгө оруулагчийн хүсэлтийг үндэслэн Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9.1-д заасны дагуу батлуулсан стандартын дагуу техникийн нөхцөлийг хангагч олгоно.

12.3.Техникийн нөхцөл өөрчлөгдвөл хангагч нь захиалагч, хөрөнгө оруулагчид мэдэгдэж техникийн нөхцөлд өөрчлөлт оруулах буюу шинээр олгоно.

12.4.Техникийн нөхцөлд тусгагдсан шаардлагыг зөрчихийг хориглоно.

12.5.Техникийн нөхцөлд хэрэглэгчийг холбох цэгийн шугам хоолойн өмчлөгч, эзэмшигчийг заасан байна.

### **13 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл, түүний ангилал**

13.1.Ус хангамж, ариутгах татуургыг шинээр барьж байгуулах болон түүний ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан дараах үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгоно:

13.2.1.ус хангамжийн эх үүсвэрийн болон ус олборлох, боловсруулах, цэвэршүүлэх барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ;

13.2.2. цэвэр ус дамжуулах, түгээх шугам сүлжээний, ус дамжуулах төвийн ашиглалт, засвар, үйлчилгээ;

13.2.3 бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ;

13.2.4.бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ;

13.2.5.ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ;

13.2.6.суурин газрын ус түгээх байрны ашиглалт, засвар, үйлчилгээ;

13.2.7.төвлөрсөн бус ус хангамжийн үйлчилгээ;

13.2.8.бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ;

13.2.9. ус хангамжийн систем, түүний барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтын ажил;

13.2.10. бохир ус, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, түүний барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтын ажил;

13.2.11.Цэвэр ус дамжуулах, түгээх үйлчилгээ;

**13.2.12.Лаг боловсруулах, ашиглах, устгах үйл ажиллагаа.**

13.3.Энэ хуулийн 13.1-д заасан тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зохицуулна.<sup>16</sup>

#### **14 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авах**

14.1.Ус хангамж, бохир ус ариутгах татуургын систем, цэвэрлэх байгууламжийн барилга угсралт, ашиглалт, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулахыг сонирхогч хуулийн этгээд тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ Зохицуулах хороонд гаргана.

14.2.Тусгай зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл, шаардлага болон тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдох харилцааг Зохицуулах хорооноос баталсан журмаар зохицуулна.

#### **15 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах**

15.1. Ус хангамж, бохир ус ариутгах татуургын систем, цэвэрлэх байгууламжийн барилга угсралт, ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа 3 жил байна.

15.2.Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө 60-аас доошгүй хоногийн өмнө гаргана.

15.3.Тусгай зөвшөөрөл нь түүнийг олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

#### **17 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг**

17.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь үүрэг хүлээнэ:

17.1.1.тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй байх;

17.1.2.хууль тогтоомж, холбогдох норм, стандарт, дүрэм, журам, тусгай зөвшөөрөлд заасан нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрөл олгогчийн шийдвэрийг дагаж мөрдөх;

---

<sup>16</sup> Зөвшөөрлийн тухай хууль баьлагдах хүртэл энэ хуулийн нэрийг ашиглана.

17.1.3.санхүүгийн тайлан бүртгэлийг тусгай зөвшөөрөл олгосон үйл ажиллагааны төрөл тус бүрээр, тусгай зөвшөөрөлд хамаарахгүй үйл ажиллагааны тайлан бүртгэлээс тусад нь хөтлөх;

17.1.4.аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайланг тусгай зөвшөөрөл олгогчид жил бүр гаргаж өгөх;

17.1.5.тусгай зөвшөөрлийн төрөлд тусгагдсан үйлчилгээг хэрэглэгчид үзүүлэх;

17.1.6.энэ хуулийн 11.1.6-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд тусгай зөвшөөрөл олгогчид мэдэгдэх, зөвшөөрөл авах;

17.1.7.тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын эрх бүхий ажилтнаас эрх мэдлийнхээ хүрээнд тавьсан шаардлагыг биелүүлэх, өөрийн байр, байгууламжид нэвтрүүлэх, ажил үүргээ биелүүлэх нөхцөлөөр хангах;

17.1.8.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн техник, эдийн засгийн үйл ажиллагаанд үнэлгээ өгөхөд шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь үнэн зөвөөр тусгай зөвшөөрөл олгогчид хүргүүлж байх;

17.1.9.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг өргөтгөх, шинэчлэх 5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж тусгай зөвшөөрөл олгосон байгууллагад хүргүүлэх;

17.1.10.үйл ажиллагаагаа тодорхой хугацаагаар зогсоох шаардлагатай бол тусгай зөвшөөрөл олгогчид 6-аас доошгүй сарын өмнө мэдэгдэх;

17.1.12.тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үзүүлэх үйлчилгээний тарифыг Зохицуулах хороогоор хянуулж, батлуулах;

17.1.13.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, хүний нөөц, техник технологи, санхүү, эдийн засгийн үзүүлэлтийн талаарх үнэн зөв мэдээллийг Зохицуулах хороонд жил бүр хүргүүлэх, мэдээлэлд орсон өөрчлөлтийн талаар 14 хоногийн дотор мэдээллэх.

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### **ХАНГАГЧ, ХЭРЭГЛЭГЧИЙН ХАРИЛЦАА**

#### **18 дугаар зүйл.Гэрээ**

18.1.Хангагч, хэрэглэгчийн хоорондын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой харилцааг энэ хууль, цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ /цаашид "гэрээ" гэх/-гээр зохицуулна.

18.2.Хангагч нь Зохицуулах хорооны баталсан аж ахуйн харилцааны дүрмийн дагуу хэрэглэгчтэй гэрээ байгуулна.

18.3.Энэ хуулийн 13.2-т заасан гэрээнд нийлүүлэх цэвэр ус болон татан зайлуулах бохир усны хэмжээ, чанар, найрлага, гэрээг дүгнэх хугацаа, төлбөр тооцооны арга, талуудын эрх, үүрэг, хариуцлага, хохирол тооцох журам болон шаардлагатай бусад зүйлийг тусгана.

18.4.Тарифт орох өөрчлөлтийн талаар түүнийг мөрдөж эхлэхээс 30 хоногийн өмнө , төлөвлөгөөт засвар хийх үед цэвэр усаар хангах үйл ажиллагааг түр зогсоох тухай хэрэглэгчид урьдчилан мэдэгдэх буюу хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.

18.5.Хангагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй.

### **19 дүгээр зүйл.Хангагчийн эрх, үүрэг**

19.1.Хангагч дараах эрхтэй:

19.1.1.хэрэглэгчийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид үзлэг, шалгалт хийж заавар, зөвлөгөө өгөх;

19.1.2.хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах,<sup>17</sup> учирсан хохирлоо төлүүлэхийг шаардах;

19.1.3.хангагчийн эрх бүхий ажилтан ажил, үүргийн шаардлагаар хэрэглэгчийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийх, энэ зорилгоор хашаа, орон байранд нэвтрэх;

19.1.4.хэрэглэсэн цэвэр, бохир усны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй хэрэглэгчдийн цэвэр усаар хангах гэрээг цуцлах, энэ хуулийн 23 дугаар зүйлд заасныг зөрчиж ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын зурваст буусан иргэн, хуулийн этгээдэд техникийн нөхцөл олгох, гэрээ байгуулахаас татгалзах;

19.1.5.холбогдох хууль тогтоомж зөрчсөн үйлдэлд нь эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан шаардлага болон энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу хэрэглэгчид үзүүлэх ус хангамжийн үйлчилгээг хязгаарлах, түдгэлзүүлэх;

19.2.Хангагч дараах үүрэгтэй:

19.2.1.гэрээний нөхцөлд тохирсон тоо, хэмжээ, холбогдох норм, дүрэм, журам, стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах,

---

<sup>17</sup> 1 хэрэглэгч, 1 хэсэг хэрэглэгч /орон сууц/ ялгамжтай зохицуулах уу



хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах, технологийн дагуу цэвэрлэх, чанар, аюулгүй байдлын шаардлагад хяналт тавих;

19.2.2.хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулахад зориулсан тоног төхөөрөмж суурилуулах, туршилт тохируулга хийж, аюулгүй ажиллагааны заавар зөвлөгөөгөөр хангах;

19.2.3.ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаарх хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөх;

19.2.4.өөрийн ашиглалт, өмчлөлд байгаа инженерийн барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжид технологийн шаардлагын дагуу засвар, үйлчилгээ, шинэчлэлтийг тогтоосон хугацаанд нь хийх;

19.2.5.гэнэтийн осол, аваар гарсан болон зайлшгүй урьдчилан сэргийлэх, засвар, үйлчилгээ хийх үед энэ тухай хэрэглэгчид мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээ авах;

19.2.6.хангагч 24 цагаас дээш хугацаагаар хэрэглэгчийн ус хангамжийг хязгаарлах тохиолдолд нормд заасан хэмжээний зөөврийн усаар хэрэглэгчийг хангах;

19.2.7.үйлчилгээний тарифын хэмжээ тогтоох саналыг боловсруулж, Зохицуулах хороогоор батлуулж, мөрдөх;

19.3.Хангагч хууль тогтоомж, гэрээнд заагаагүй нөхцөл, шаардлага тавьж хэрэглэгчийн эрхийг хязгаарлах, энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан техникийн нөхцөл олгохоос үндэслэлгүйгээр татгалзахыг хориглоно.

19.4.Хангагч нь шинээр барилга байгууламж холбох техникийн нөхцөлийг шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг үндэслэн олгоно.

19.5.Хангагч нь үйлдвэрлэлийн осол, аваар гаргасан, эд хөрөнгийн хохирол учруулсан, техникийн гэмтэл гарсан тохиолдолд зөрчлийг арилгахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээ авна.

19.6.Хангагч нь ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх засвар, үйлчилгээ хийх, хэрэглээг хязгаарлах бол хязгаарлалтын талаар хэрэглэгчид урьдчилан мэдэгдэх, шаардлагатай арга хэмжээ авна.

19.7.Хангагч нь тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн шугам сүлжээ, барилга байгууламж, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг холбосон бол ашиглалтын төлбөр төлөх үүрэгтэй.

19.8. Төвлөрсөн бус ус хангамжийг эх үүсвэрээс /худаг/ хангагчийн эрх, үүрэг

19.8.1.шаардлага хангасан унд, ахуйн хэрэглээний усаар хангах;

19.8.2.ажиллах цагийн хуваарийг хэрэглэгчид ойлгомжтой, тодорхой байршуулах;

19.8.3.ус хангамжийн эх үүсвэрт тогтмол шинжилгээ хийлгэх;

19.8.4. үйл ажиллагааны тайлан мэдээг холбогдох байгууллагад тогтмол хугацаанд хүргүүлэх;

19.8.5.төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламжийн засвар, үйлчилгээ болон түүнд шаардагдах санхүүжилтийн хэмжээг тогтоосон төлөвлөгөө боловсруулах;

19.8.6.төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж буй усны нөөцийн сав болон бусад тоног төхөөрөмж эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан байна.<sup>18</sup>

19.9.аж ахуйн нэгж, байгууллага гамшиг, ослын үед гал түймрийг унтраах ус хангамжаар өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй хангана.<sup>19</sup>

## **20 дугаар зүйл.Хэрэглэгчийн эрх, үүрэг**

20.1.Хэрэглэгч дараах эрхтэй:

20.1.1.энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан гэрээний дагуу стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангуулах, хэрэглээнээс гарсан бохир усаа хангагчийн шугам сүлжээнд нийлүүлэх, саарал усыг ашиглах, тэдгээрт хамаарах бусад үйлчилгээг авах эрхтэй.

20.1.2.Төлбөрийн чадваргүй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн унд, ахуйн хэрэглээний цэвэр усаар хангуулах, хэрэглээнээс гарсан бохир усаа хангагчийн шугам сүлжээнд нийлүүлэх үйлчилгээний төлбөрөөс хөнгөлөлт үзүүлэх тухай журмыг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

20.1.3.хангагч үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд үйлчилгээний төлбөрийг бүрэн буюу зарим хэсгийг нь төлөхөөс татгалзах, хохирлоо нөхөн төлүүлэхээр хангагчаас нэхэмжлэх

20.1.4.хангагч байгууллага нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг 11-14 дүгээр зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй.

<sup>18</sup> 2019.09.22-ны өдрийн уулзалтаар энэ төрлийн заалт нэмж тусгах санал оруулсныг тусгав.

<sup>19</sup> **Галын аюулгүй байдлын тухай** /шинэчилсэн найруулга3.1.5.“гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж” гэж барилга байгууламж дахь гал түймрийг илрүүлэх, мэдээлэх, унтраах автомат тоног төхөөрөмж, утаа зайлуулах систем, гал унтраах усан хангамж, хүн нэг бүрийн болон нийтийн тусгай аврах хэрэгслийг; ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА. 18 дугаар зүйл.Галын аюулгүй байдлыг хангах үндэслэл. 18.3.Барилга байгууламж, гэр хорооллыг гал түймэр унтраах автомашин чөлөөтэй хүрэлцэн очих зам, байрлах тусгайлан талбайтай, гал түймэр унтраах үед ашиглах усан хангамжтай байхаар төлөвлөнө. **Гамшгаас хамгаалах тухай хуулийн** 16.3.Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй.

20.2.Хэрэглэгч дараах эрх, үүрэгтэй:

20.2.1.цэвэр усаар хангуулах болон хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах талаар гэрээнд заасан нөхцөлийг биелүүлэх;

20.2.2.цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх;

20.2.3.ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаарх хууль тогтоомж, норм, стандарт, техникийн болон аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөх;

20.2.4.хангагчийн төлөөлөгчийг энэ хуулийн 14.1.1-д заасан үйл ажиллагаагаа явуулах нөхцөлөөр хангах;

20.2.5.хангагчаас цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах, саарал усыг ашиглах техникийн нөхцөл авах;

20.2.6.өөрийн эзэмшилд байгаа шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах, засвар, үйлчилгээг, баталгаажуулалтыг бүрэн хариуцан гүйцэтгэх;

20.2.7.өөрийн эзэмшилд байгаа тоног төхөөрөмж, шугам сүлжээнд гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө, бололцоогүй бол хангагчаар хийлгэж, гарсан зардлыг төлөх;

20.2.8.хангагчаас олгосон техникийн нөхцөл, зөвшөөрөл, батлагдсан зураг төслийн дагуу өөрийн эзэмшлийн шугамаас бусад хэрэглэгчийг холбуулах;

20.2.9.энэ хуулийн 15.1.10-т заасны дагуу бусдад цэвэр ус түгээх, тэдгээрийн хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах нөхцөлд хангагч байгууллагаас үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийг баталсан хэмжээнд авах;

20.2.10.өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид гарсан болон гарч болох осол, гэмтлийн талаар хангагчид мэдээлэх, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, усны хэмжих, хянах хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцах;

20.2.11.үйлчилгээний суурь тарифыг тогтмолоор, усны хэрэглээний төлбөрийг тоолуурын заалтаар эсхүл гэрээний дагуу нормоор тооцож төлөх.

20.2.12. Хэрэглэгч өөрийн өмчлөлийн шугам сүлжээ, барилга байгууламж, тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчийг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр холбосон бол төлбөр нэхэмжлэх эрхтэй.

**21 дүгээр зүйл.Цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох нөхцөл**

21.1.Хангагч дор дурдсан нөхцөлд хэрэглэгчид урьдчилан мэдэгдэхгүйгээр цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагаанд хязгаарлалт хийж болно:

21.1.1.ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжид эрчим хүчний гэнэтийн тасалдал гарсан;

21.1.2.гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас усны хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай болсон;

21.1.3.ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжид ноцтой гэмтэл гарсан.

21.1.4. Хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд аюултай нөхцөл байдал үүссэн.

21.2.Хангагч дор дурдсан нөхцөлд хэрэглэгчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагааг хязгаарлах буюу зогсоох хүртэл арга хэмжээ авна:

21.2.2.ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд төлөвлөгөөт урсгал болон их засвар хийх болсон;

21.3.Хангагч дор дурдсан нөхцөл бүрдсэн тохиолдолд хэрэглэгчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр зөрчлийг арилгах хүртэлх хугацаагаар цэвэр усны хэрэглээг хязгаарлах буюу зогсоох хүртэл арга хэмжээ авна:

21.3.1.цэвэр усны алдагдал, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн гэмтлийг тогтоосон хугацаанд засварлаагүй;

21.3.2.16.2.4.ус хангамжийн байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд хангагчийн зөвшөөрөлгүйгээр холбосон;

21.3.3.усны тоолуурын битүүмжлэл, байрлал, холболтыг дураараа өөрчилсөн;

21.3.4.энэ хуулийн 24.1-д заасны дагуу тогтоосон бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээг хангаагүй бохир ус нийлүүлсэн.

21.3.5.хэрэглэгч усны хэрэглээний төлбөрөө 60 хоног, түүнээс дээш хугацаагаар төлөөгүй, эсхүл баталгаажуулаагүй усны тоолуур ашигласан.

21.3.6.усны тоолуургүй хэрэглэгч гэрээнд заасан хэрэглэгчийн тоонд орсон өөрчлөлтийг бүртгүүлээгүй нь тогтоогдсон.

21.3.7.ус хангамж, ариутгах татуургын хяналтын улсын байцаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй.

21.3.8.техникийн нөхцөл зөрчсөн

21.3.9.хангагч усны төлбөр барагдуулах тухай сануулгыг хэрэглэгчид 2-оос доошгүй удаа бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

## **22 дугаар зүйл.Мэдээлэл өгөх, мэдээллийн нууц хадгалах**

22.1. Хангагч, дамжуулагч, түгээгч, хэрэглэгч нь ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний талаарх мэдээ, мэдээллийг хуульд заасан хугацаанд хадгална.

22.2. Ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээг боловсронгуй болгох, мэдээллийн нэгдсэн сан дахь мэдээллийг шинэчлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллийг өмчлөгч, хангагч, дамжуулагч, түгээгч байгууллагууд холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд, мэдээллийн ангилал, хэлбэрт нийцүүлэн гаргаж хүргүүлнэ.

22.3. Ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээний талаарх мэдээллийн нэгдсэн санд өгөх мэдээллийн төрөл, ангилал, давтамж зэргийг нарийвчлан зохицуулсан журмыг ус хангамж, ариутгах татуургын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.<sup>20</sup>

22.4. Эрх бүхий байгууллага хяналт, шалгалт хийх чиг үүргийн хүрээнд ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний өмчлөгч, хангагч, дамжуулагч, түгээгч байгууллага болон хэрэглэгчээс энэ хуульд хамаарах асуудлын хүрээнд үүссэн бичиг баримт, мэдээлэлтэй танилцах, түүнээс хуулбарлан авах, лавлагаа гаргуулах эрхтэй.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

### **УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ АШИГЛАЛТ, ӨМЧЛӨЛ**

#### **23 дугаар зүйл. Ус хангамж, ариутгах татуурга**

23.1. Улсын онц чухал объектод хамаарах болон суурин газрын ундны ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтыг дотоодын цэрэг гүйцэтгэж, бусад ус хангамжийн эх үүсвэр нь энгийн харуул хамгаалалттай байна.

23.2. Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр нь хамгаалалтын болон эрүүл ахуйн бүстэй байх бөгөөд тэдгээрийн дэглэмийг Усны тухай хуулийн 22.3, 22.4-т заасны дагуу тогтооно.

23.1. Улсын онц чухал объектод хамаарах болон суурин газрын ундны ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, **цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ,**<sup>21</sup> цэвэрлэх байгууламж, тэдгээрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг газрын төлбөрөөс чөлөөлнө.

23.4. Хамгаалалтын зурвасын дотор тарьсан, ургасан мод, бут нь шугам сүлжээнд гэмтэл учруулахаар буюу үзлэг, үйлчилгээ хийхэд саад болохоор бол

<sup>20</sup> 2019.09.22-нд Мэдээлэл өгөх журам батлах тухай зохицуулалт, журам гаргах, 33 үү БХБЯ-уу харач гэсний дагуу дээрх заалтыг нэмж тусгав.

<sup>21</sup> цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ тэдгээрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг газрын төлбөрөөс чөлөөлхгүй байж болно. Энэ талаар санал авах.

мод, бутны өмчлөгч, эзэмшигч нь түүнийг шилжүүлэн суулгах, тайрах, огтлох үүрэгтэй.

23.5.ус хангамж, ариутгах татуургын хяналтын улсын байцаагч ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээнд үзлэг, үйлчилгээ хийх, хяналт хэрэгжүүлэх зорилгоор хамгаалалтын зурвасын дагуу бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газар, барилга байгууламжид нэвтрэн орох, дайран өнгөрөх эрхтэй.

23.6.Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтэд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллага, ус хангамж, ариутгах татуургын хяналтын улсын байцаагч хяналт тавина.<sup>22</sup>

23.7.Энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах байдлаар тогтоож, хэрэгжилтийг хангуулна:

23.7.1.төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн /худаг/ эрүүл ахуйн бүсийг 50 метр, хамгаалалтын бүсийг 200 метрээс багагүй зайд;

23.7.2.төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийг Усны тухай хуулийн 22.3-т заасны дагуу;

23.7.3.төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт урсгал уснаас шууд тэжээгдэх худгийн усыг ашиглахдаа хамгаалалтын бүсийг мэргэжлийн хяналтын байгууллагын хот, суурины ус хангамж, ариутгах татуургын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн 500 метрээс багагүй зайд;

23.7.4.урсгал усыг төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа тохиолдолд тухайн газрын хөрс, чулуулгийн тогтолцоо, голын урсацыг харгалзан хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг Усны тухай хуулийн 22.4-т заасны дагуу.

23.8.Улсын болон аймгийн зэрэглэлтэй хотын ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг тухайн усны эх үүсвэрийн тэжээлийн бүс болон түүнтэй гидравлик холбоотой гол, нуурын ус хуримтлуулах талбайг хамруулан тогтоож болно.

---

<sup>22</sup> Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолын хавсралт “АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР” –ийн 4.1.14. Туул гол, түүний цутгал Сэлбэ, Улиастай, Баянгол, Зүүн салаа, Баруун салаа, Толгойт зэрэг голуудад хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлж, үерийн далан болон хамгаалалтын бүсэд буусан айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг нүүлгэх бэлтгэл ажлыг хангаж, үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх.

Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолын хавсралт “АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР” –ийн 4.4.2. агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх чиглэлээр албан тушаалтан, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, байгаль орчны хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллах;

23.9.Төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугамын тэнхлэгээс хоёр тийш таван метрт хамгаалалтын зурвас тогтооно.

23.10.Хотын доторх цэвэр усны дамжуулах, түгээх, бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам ашиглалтын явцад засвар, үйлчилгээ хийх хамгаалалтын зурвас газартай байна.

23.11.Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд Усны тухай хуулийн 22.2.1-д зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

23.12.1.газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис хадгалах, боловсруулах, үйлдвэрлэх;

23.12.2.байгаль орчин, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөөгүй бордоо ашиглан таримал ургамал тарих, бодис, арга технологи хэрэглэн хөнөөлт шавж, мэрэгчийг устгах;

23.12.3.унд, ахуйн бус зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх

23.12.4.газар эзэмших, ашиглах, өмчлөх эрх олгох.

23.13.Усны чанарын шинжилгээний дээж авах цэг, давтамжийг эрүүл мэндийн хяналтын байгууллагаас тогтоож, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

23.14.Ус хангамжийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс, эх үүсвэрийн барилга байгууламжид хангагч байгууллагын зөвшөөрөлгүйгээр нэвтрэхийг хориглоно.

23.15.Иргэн хувийн хэрэгцээндээ зориулж гаргасан усны эх үүсвэрийг ашиглах болон бусад хэрэглэгчийг усаар хангах нөхцөлд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөнө.

23.16.Шинээр төлөвлөж байгаа барилга байгууламжийн хэрэглээнээс гарсан бохир усыг дахин ашиглах асуудлыг батлагдсан стандарт, норм, дүрмийн дагуу хэрэгжүүлнэ.

23.17.Уул уурхай, эрчим хүчний үйлдвэр нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн дахин давтан ашиглана.

23.18.Бохир ус татан зайлуулах шугамын тэнхлэгээс хоёр тийш зургаан метрээс багагүй зайд барилга байгууламж, шугам сүлжээг барихыг хориглоно.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ**

### **ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ<sup>23</sup>**

---

<sup>23</sup> Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолын хавсралт “АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР” –ийн 4.2.8. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж болон бусад хот, суурин газрын ариутгах татуургын байгууламж, үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологиор шинэчлэх;

## 24 дүгээр зүйл. Цэвэрлэх байгууламж

24.1. Технологийн хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэрлэх байгууламжид нийлүүлэхдээ стандартад заасан бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээг баримтална.

24.2. Цэвэрлэх байгууламжийн байршлыг дараах зүйлийг харгалзан тогтооно:

24.2.1. хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;

24.2.2. байгалийн гэнэтийн аюул /усны үер, гал түймэр, газар хөдлөлт г.м/-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө;

24.2.3. цэвэрлэх байгууламжийг өргөтгөх боломж;

24.2.4. хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоох талбай;

24.2.5. ажиллагсдын эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын болон аюулгүй ажиллагааны нөхцөл.

24.3. цэвэрлэх байгууламж нь хаягдал усыг дахин ашиглах технологи бүхий тоног төхөөрөмжтэй байна.

24.5. цэвэрлэх байгууламж нь үүссэн лагийг хүн амын эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй түвшинд хүртэл устгах<sup>24</sup> арга хэмжээ авна.

25.6. цэвэрлэх байгууламж лагийг дахин боловсруулах үйл ажиллагаа эрхэлж болно.<sup>25</sup>

24.7. лагийг тээвэрлэх, дахин боловсруулах, ашиглах, устгахтай холбогдох журам, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг эрүүл мэнд, байгаль орчин болон ариутгах татуургын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

24.8. лагийн шинж чанар, ангилалтай холбоотой стандартыг эрүүл мэнд, байгаль орчин болон ариутгах татуургын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран боловсруулж батална.<sup>26</sup>

24.9. лаг болон цэвэрлэсэн бохир ус холбогдох норм, стандартын шаадлага хангаж байгаа эсэхэд<sup>27</sup> эрүүл мэнд, байгаль орчны хяналтын алба, технологийн горимд дэд бүтцийн хяналтын алба тус тус хяналт тавина.<sup>28</sup>

---

<sup>24</sup> Хоргүйжүүлэх гэснийг устгах гэж өөрчлөв

<sup>25</sup> L3388-MON, Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл – нэмэлт санхүүжилт төслийн удирдах нэгжээс 2018.09.21-ний өдрийн 209 тоот албан бичгээр ирүүлсэн саналын 6-р зүйл.

<sup>26</sup> L3388-MON, Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл – нэмэлт санхүүжилт төслийн удирдах нэгжээс 2018.09.21-ний өдрийн 209 тоот албан бичгээр ирүүлсэн саналын 8-р зүйл.

<sup>27</sup> “цэвэрлэсэн бохир усны болон лагийн найрлагад” гэснийг “лаг болон цэвэрлэсэн бохир ус холбогдох норм, стандартын шаадлага хангаж байгаа эсэхэд” гэж өөрчлөн найруулав.

<sup>28</sup> Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолын хавсралт “АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР” –ийн Үндэслэл хэсэгт: Усны бохирдлын гол эх үүсвэр нь цэвэрлээгүй болон дутуу цэвэрлэсэн үйлдвэрлэлийн болон ахуйн бохир ус, стандартын шаардлага хангахгүй ариун цэврийн



## **25 дугаар зүйл. Урьдчилсан цэвэрлэх байгууламж**

25.1. Үйлдвэрлэлийн хэрэглээнээс гарсан бохир усыг урьдчилан цэвэрлэх байгууламжаар зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлэсний дараа татан зайлуулах төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлэх, технологийн хэрэглээндээ эргүүлэн ашиглана.

## **26 дугаар зүйл. Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламж<sup>29</sup>**

26.1. Төвлөрсөн ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдоогүй, бие даасан шийдэл бүхий төвлөрсөн бус ариун цэврийн байгууламж /жорлон/ нь хөрсөнд нэвчдэггүй, стандартын шаардлага хангасан байх бөгөөд энэхүү арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

26.2. Улсын чанартай авто замын дагуу байрлах зорчигч үйлчилгээний болон шатахуун түгээх газар нь ариутгах татуургын шугам сүлжээ бүхий ариун цэврийн өрөөтэй байх бөгөөд энэхүү арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

26.3. Төвлөрсөн ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдоогүй, хөрсөнд нэвчдэггүй, стандартын шаардлага хангасан төвлөрсөн бус ариун цэврийн байгууламж ашиглаж буй иргэн, хуулийн этгээдэд улсын болон аймаг нийслэлийн төсвөөс санхүүгийн дэмжлэг, татаас үзүүлж болно.<sup>30</sup>

## **27 дугаар зүйл. Барилга байгууламж, шугам сүлжээний өмчлөл**

27.1. Хүн амын унд, ахуйн хэрэглээний ус хангамжийн эх үүсвэр, эх үүсвэрийн барилга байгууламж төрийн өмчид байна.

27.2. Цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байна.

27.3. Цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээг эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж даатгалд хамруулна.

---

байгууламж, хог хаягдал, хөрс болон агаарын бохирдол, уул уурхайн болон барилгын үйлдвэрлэлээс үүдэлтэй лаг шавар, хагшаас зэрэг байна.

<sup>29</sup> Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолын хавсралт “АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР” –ийн Үндэслэл хэсэгт: Улаанбаатар хотын гэр хороолол тэлэхийн хэрээр стандартын шаардлагад нийцэхгүй, доторлогоогүй ариун цэврийн байгууламж нэмэгдэж байгаа нь ус, хөрсний бохирдлын гол эх үүсвэр, халдварт өвчин дэгдэх суурь нөхцөл болж байна. Улаанбаатар хотын гэр хорооллын 190 мянга гаруй өрхийн ариун цэврийн байгууламжийн 80 хувь нь стандартад нийцэхгүй байна.

Мөн тэнд 4.1.10. хот, суурин газрын гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцүүлэх замаар боловсронгуй болгох;

<sup>30</sup> L3388-MON, Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл – нэмэлт санхүүжилт төслийн удирдах нэгжээс 2018.09.21-ний өдрийн 209 тоот албан бичгээр ирүүлсэн саналын 9-р зүйл.

**ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ хууль /2017/ 10 дугаар зүйл. Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг 10.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараахь үйл ажиллагааг хориглоно: 10.3.6. аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах;**

27.4.Цэвэр ус дамжуулах зориулалттай 32 мм-ээс бага, бохир ус цуглуулах, татан зайлуулах зориулалттай 160 мм-ээс бага диаметртэй шугам, сүлжээ хувь хүн, хуулийн этгээдийн өмчид байж болно.<sup>31</sup>

27.5.Цэвэр усны дамжуулах, түгээх шугам, сүлжээнээс 500 метр хүртэлх зайд төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр гаргахыг хориглоно.

27.6.Энэ хуулийн 27.1-д заасан барилга байгууламж, шугам сүлжээ, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг зохих тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж болно.

27.7.Ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний өмчлөх эрх өөрчлөгдөх нь эдгээр барилга байгууламж, шугам сүлжээний үйл ажиллагааг зогсоох үндэслэл болохгүй.

27.8.Хангагч унд, ахуйн хэрэглээний, үйлдвэрлэлийн зориулалттай усаар хангах үйлчилгээг зэрэг үзүүлж байгаа тохиолдолд болзошүй усны хомсдол үүсэх болон технологийн хүчин чадал буурсан тохиолдолд эхний ээлжинд унд, ахуйн хэрэглээний усаар хангах үйлчилгээг үзүүлнэ.

27.9.Унд, ахуйн хэрэглээний зориулалттай цэвэр усыг хүнсний зориулалтаас бусад тохиолдолд үйлдвэрлэлийн хэрэгцээнд ашиглахыг хориглоно.<sup>32</sup>

## **28 дугаар зүйл.Цэвэр, бохир усны хэмжээ тогтоох**

28.1.Хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр усны хэмжээг энэ хуулийн 14 дүгээр 13 дугаар зүйлд заасны дагуу байгуулсан гэрээ, эрх бүхий байгууллагаар баталгаажсан усны тоолуурын заалтыг үндэслэн тооцно.

28.2.Усны тоолуургүй хэрэглэгчийн хэрэглэсэн унд, ахуйн ус, хэрэглээнээс гарсан бохир усны хэмжээг байгаль орчин, ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэрэглээний жишиг, нормыг үндэслэн тодорхойлно.

28.3.Тооцооны хэмжих хэрэгслийн гэмтэл, эвдрэл нь хэрэглэгчээс шалтгаалаагүй, эсхүл тооцооны хэмжих хэрэгслийг шалгаж засварлах, баталгаажуулах зорилгоор шугамаас салгасан бол өмнөх 3 сард хэрэглэсэн цэвэр ус, татан зайлуулсан бохир усны хэмжээний дунджаар тооцно.

28.4.Хэрэглэгч эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр тооцооны хэмжих хэрэгслийг ус хангамж, ариутгах татуургын шугам, сүлжээнд хууль бусаар холбосон бол нотлох баримтаар тогтоогдоогүй хугацааг доод тал нь 5 жилээр тооцож төлбөрийг шүүхэд нэхэмжилнэ.

<sup>31</sup> Найруулгыг хэрхэн өөрчлөх талаар санал авах

<sup>32</sup> 2019.09.22-ны өдрийн уулзалтаас гарсан саналыг хуулийн заалт болгон томъёолов.

28.5. Хангагч борооны болон хөрсний усыг ариутгах шугам сүлжээнд зөвшөөрөлгүйгээр нийлүүлсэн иргэн, хуулийн этгээдээс бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөр нэхэмжлэх эрхтэй.

28.6.Барилга байгууламжийн бүтэц, зохион байгуулалтаас шалтгаалан хэрэглэгч борооны болон хөрсний усыг ариутгах татуургын шугам сүлжээнд нийлүүлэх тохиолдолд хангагч байгууллагатай гэрээ байгуулж төлбөр төлнө.

28.7.Хангагч байгууллага ариутгах татуургын шугам сүлжээнд нийлүүлэх борооны болон хөрсний усны хэмжээнд хязгаарлалт тогтоож болно.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ**

### **ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА**

**29 дүгээр зүйл.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль тогтоомжийн биелэлт, түүнд тавих хяналт**

29.1. Ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд холбогдох мэргэжлийн хяналтын, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, хяналтын улсын байцаагч хяналт тавина

29.2.Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, цэвэр усны мөрдөж байгаа үнэ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөрийн үндэслэлд олон нийтийн хяналт тавина.

**30 дугаар зүйл.Маргаан шийдвэрлэх**

30.1.Арбитрын хэлэлцээртэй бол тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.

30.2.Энэ хуулийн 22.1-д зааснаас бусад тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон хангагч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг Зохицуулах хороо шийдвэрлэнэ.

30.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч нь энэ хуулийн 30.2-т заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

**31 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

31.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

31.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

31.3.Ус хангамж, ариутгах татуургын тухай хууль зөрчигчид хариуцлага торгууль оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.<sup>33</sup>

#### **40 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

27.1.Энэ хуулийг 20... оны .... дүгээр сарын ....-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---

<sup>33</sup> Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолын хавсралт “АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР” –ийн 4.5.2. байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хүлээлгэх хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэх;